



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Говь-Алтай аймаг

Алтай хот

2021 он

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Цэцэгмаа

Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022, 02.25 № 110

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07622325

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,540,851.69	182,966,243.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	1,357,259.22
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	1,357,259.22
31210	Төгрөг	0	1,357,259.22
31211	Төрийн сангийн харилцах	0	1,357,172.22
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0	87
33	АВЛАГА	0	118,122,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	118,122,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,540,851.69	63,486,984.61
35100	Түүхий эд материал	9,942,208.99	32,551,976.71
35130	Эм боох материал	9,942,208.99	32,551,976.71
35400	Хангамжийн материал	13,598,642.70	30,935,007.90
35410	Бичиг хэргийн материал	83,000.00	406,000.00
35420	Аж ахуйн материал	9,370,434.00	22,663,840.50
35440	Түлш, шатах тослох материал	1,059,792.00	550,000.00
35460	Хүнсний материал	807,166.00	2,811,375.00
35470	Бусад хангамжийн материал	2,278,250.70	4,503,792.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	337,621,817.60	404,982,061.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	337,621,817.60	404,982,061.94
39200	Биет хөрөнгө	330,137,817.60	397,498,061.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	316,137,615.97	271,931,965.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55,586,225.18	-29,428,335.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,450,000.00	57,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,950,000.00	-23,100,000.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	168,096,974.90	228,406,260.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-126,032,219.05	-123,876,866.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,774,745.00	18,219,042.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,523,073.88	-11,764,837.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,970,037.00	16,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,200,037.16	-6,639,166.88
39300	Биет бус хөрөнгө	7,484,000.00	7,484,000.00
39301	Програм хангамж	550,000.00	0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	0
39303	Бусад биет бус хөрөнгө	7,484,000.00	7,484,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	361,162,669.29	587,948,305.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	14,483,669.93
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	14,483,669.93
41300	Өглөг	0	14,483,669.93
41360	Бусад өглөг	0	14,483,669.93
41361	Байгууллагад төлөх өглөг	0	13,373,469.93
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	1,110,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	361,162,669.29	573,464,635.84
51	Засгийн газрын хувь оролцоо	361,162,669.29	573,464,635.84
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	266,741,425.20	266,741,425.20
51200	Хуримтлагдсан үр дүн	37,365,088.19	249,667,054.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-43,941,469.52	37,365,088.19
51220	Тайлант үеийн үр дүн	81,306,557.71	212,301,966.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,056,155.90	57,056,155.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	361,162,669.29	587,948,305.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	466,605,846.04	914,740,378.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,995,856.04	281,274,888.34
120	Нийтлэг татварын бус орлого	141,995,856.04	272,712,427.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	141,995,856.04	3,139,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,139,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	141,995,856.04	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	104,869,049.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	164,703,877.78
122	Тусламжийн орлого	0.00	8,562,461.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	8,562,461.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	324,609,990.00	633,465,490.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	270,092,600.00	326,730,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	270,092,600.00	326,730,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,286,050.00	152,470,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,606,050.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,180,000.00	34,348,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	500,000.00	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	118,122,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,405,600.00	42,412,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,405,600.00	42,412,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,825,740.00	111,852,590.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,825,740.00	111,852,590.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	385,299,288.33	701,664,291.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,299,288.33	701,664,291.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,702,478.12	674,316,993.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,076,034.00	266,475,284.00
210101	Үндсэн цалин	156,870,889.00	179,226,955.00
210102	Нэмэгдэл	49,200,000.00	58,422,595.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,179,000.00	4,088,583.00
210104	Урамшуулал	9,826,145.00	24,737,151.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,146,883.79	35,924,575.78
210201	Тэтгэврийн даатгал	19,370,883.79	26,220,346.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,194,000.00	2,630,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,755,200.00	1,984,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,800.00	496,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,388,000.00	4,594,229.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,908,822.00	35,373,382.00
210301	Гэрэл, цахилгаан	1,853,682.00	2,680,902.00
210302	Түлш, халаалт	33,655,140.00	32,292,480.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,545,155.00	52,461,059.00
210401	Бичиг хэрэг	1,187,500.00	1,484,750.00
210402	Тээвэр, шатахуун	12,464,760.00	16,868,396.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	676,100.00	822,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	395,000.00	1,167,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	821,795.00	32,117,713.00
2105	Нормативт зардал	26,020,023.73	206,277,973.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,885,869.73	184,454,186.79
210502	Хоол, хүнс	5,288,154.00	9,662,541.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	846,000.00	12,161,246.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,772,900.00	8,277,000.00
210604	Урсгал засвар	2,772,900.00	8,277,000.00

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	412,000.00	1,119,000.00
210702	Дотоод албан томилолт	412,000.00	1,119,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,689,434.00	1,441,034.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	42,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,950.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	0.00
210807	Газрын төлбөр	7,484.00	7,484.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	220,000.00	608,850.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	523,000.00	782,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,131,225.60	66,967,684.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,564,650.00	7,038,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,566,575.60	59,929,684.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,596,810.21	27,347,298.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,292,000.00	26,884,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,292,000.00	26,884,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,274,118.00	462,498.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,274,118.00	462,498.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,692.21	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,692.21	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	81,306,557.71	213,076,087.26
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	774,120.71
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	774,120.71
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	81,306,557.71	212,301,966.55

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,741,425.20	57,056,155.90	-43,941,469.52	279,856,111.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	266,741,425.20	57,056,155.90	-43,941,469.52	279,856,111.58
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	81,306,557.71	81,306,557.71
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,741,425.20	57,056,155.90	37,365,088.19	361,162,669.29
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	266,741,425.20	57,056,155.90	37,365,088.19	361,162,669.29
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	266,741,425.20	57,056,155.90	37,365,088.19	361,162,669.29
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	212,301,966.55	212,301,966.55
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	266,741,425.20	57,056,155.90	249,667,054.74	573,464,635.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	324,609,990.00	527,045,451.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	324,609,990.00	527,045,451.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	270,092,600.00	326,730,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	270,092,600.00	326,730,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,286,050.00	150,587,961.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,606,050.00	8,562,461.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,180,000.00	138,886,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	500,000.00	3,139,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,405,600.00	42,412,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,405,600.00	42,412,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,825,740.00	7,314,590.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,825,740.00	7,314,590.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	323,133,990.00	502,493,191.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	323,133,990.00	502,493,191.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	316,437,179.79	474,497,893.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,076,034.00	266,475,284.00
210101	Үндсэн цалин	156,870,889.00	179,226,955.00
210102	Нэмэгдэл	49,200,000.00	58,422,595.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,179,000.00	4,088,583.00
210104	Урамшуулал	9,826,145.00	24,737,151.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,146,883.79	35,924,575.78
210201	Тэтгэврийн даатгал	19,370,883.79	25,854,575.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,194,000.00	2,630,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,755,200.00	1,984,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,800.00	496,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,388,000.00	4,960,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,131,582.00	33,954,502.00
210301	Гэрэл, цахилгаан	1,853,682.00	2,680,902.00
210302	Түлш, халаалт	26,877,900.00	30,873,600.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,376,100.00	23,124,454.00
210401	Бичиг хэрэг	1,056,000.00	1,667,750.00
210402	Тээвэр, шатахуун	12,464,760.00	16,358,604.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	676,100.00	822,600.00
210404	Ном, хэвлэл	0	140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	395,000.00	1,159,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	784,240.00	2,976,500.00
2105	Нормативт зардал	15,040,596.00	95,666,344.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,472,296.00	74,625,694.00
210502	Хоол, хүнс	4,111,050.00	6,906,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,457,250.00	14,134,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,999,900.00	8,308,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	313,900.00
210604	Урсгал засвар	2,999,900.00	7,995,000.00
2107	Томилголт, зочны зардал	412,000.00	1,119,000.00
210702	Дотоод албан томилолт	412,000.00	1,119,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,689,434.00	1,441,034.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	42,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	89,950.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	0
210807	Газрын төлбөр	7,484.00	7,484.00

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	220,000.00	608,850.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	523,000.00	782,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,564,650.00	8,483,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,564,650.00	8,483,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,696,810.21	27,995,298.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,392,000.00	27,532,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,392,000.00	27,532,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,274,118.00	462,498.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,274,118.00	462,498.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,692.21	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,692.21	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,476,000.00	24,552,259.22
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,476,000.00	23,195,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,476,000.00	23,195,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,476,000.00	23,195,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,476,000.00	23,195,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,476,000.00	-23,195,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	1,357,259.22
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,357,259.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	387,280,400.00	374,637,819.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,280,400.00	374,637,819.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,780,400.00	373,145,019.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,700,000.00	244,745,317.00
210101	Үндсэн цалин	162,300,000.00	159,496,988.00
210102	Нэмэгдэл	57,000,000.00	58,422,595.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,200,000.00	4,088,583.00
210104	Урамшуулал	23,200,000.00	22,737,151.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,380,000.00	33,436,152.78
210201	Тэтгэврийн даатгал	24,310,000.00	23,366,152.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,630,000.00	2,630,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,000.00	1,984,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	496,000.00	496,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,960,000.00	4,960,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,412,000.00	33,954,502.00
210301	Гэрэл, цахилгаан	2,800,000.00	2,680,902.00
210302	Түлш, халаалт	31,212,000.00	30,873,600.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,023,400.00	18,586,650.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,140,550.00
210402	Тээвэр, шатахуун	13,493,400.00	13,492,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	822,600.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,780,000.00	1,159,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	1,832,400.00
2105	Нормативт зардал	25,374,300.00	21,489,664.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,974,300.00	14,966,984.00
210502	Хоол, хүнс	5,400,000.00	3,122,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	3,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,008,900.00	17,003,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,008,900.00	9,008,900.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,995,000.00
2107	Томилот, зочны зардал	320,000.00	244,000.00
210702	Дотоод албан томилот	320,000.00	244,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,300,000.00	1,441,034.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	42,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	7,484.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	800,000.00	608,850.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,480,000.00	782,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,261,800.00	2,243,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,261,800.00	2,243,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,492,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,492,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,492,800.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	387,280,400.00	375,994,992.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,730,900.00	326,730,900.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	326,730,900.00	326,730,900.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,412,000.00	41,949,502.00
320001	Орон нутгийн төсвөөс	42,412,000.00	41,949,502.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,137,500.00	7,314,590.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,137,500.00	7,314,590.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,357,172.22

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,587,874.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,587,874.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,547,874.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,729,967.00
210101	Үндсэн цалин	19,729,967.00
210104	Урамшуулал	2,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,488,423.00
210201	Тэтгэврийн даатгал	2,488,423.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,537,804.00
210401	Бичиг хэрэг	527,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,866,504.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,144,100.00
2105	Нормативт зардал	74,176,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,658,710.00
210502	Хоол, хүнс	3,783,570.00
210503	Нормын хувцас, zeелөн эдлэл	10,734,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	875,000.00
210702	Дотоод албан томилолт	875,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,240,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,240,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,040,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,040,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150,587,961.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,587,961.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,562,461.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,886,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,139,500.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	87.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	87.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлэх хүрээний хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй чанартай үзүүлж, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх”-д оршино гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 385.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63 хувиар буюу 226.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө данс эхний үлдэгдэлгүй, 1.3 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна

Бараа материалын дансны үлдэгдэл 63.5 сая төгрөг болж 40.0 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 135.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 164.7 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 260.1 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 599.8 сая төгрөг болж 40.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 23.2 сая төгрөгийн, хандиваар 104.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 87.7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд 49.9 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан байна.

Авлага дансанд эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 118.1 сая төгрөг нь ЭМДСангаас авах авлага ба тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Өглөг дансанд эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 14.5 сая төгрөг нь эм боох материал, нормын хувцас зөөлөн эдлэл болон халаалтын өглөг ба тооцоо нийлж тулган баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 573.5 сая төгрөг болж 212.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 249.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 23.1 сая төгрөгөөр бууруулж, 387.3 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд гэсэн 2 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээс 326.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 42.4 сая төгрөгийн, гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 18.1 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 100% эрүүл мэндийн даатгалын сангаас 7.3 сая төгрөг буюу батлагдсан санхүүжилтийн 40.3 хувийг бүрдүүлж оны эцэст орон нутгийн төсвийн хэмнэлт болох 0.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 1.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн дээд шатны төсөв захирагчаас 138.9 сая төгрөг, хандивын тусламжаар 8.6 сая төгрөг, шинжилгээний орлогоос 3.1 сая төгрөг нийт 150.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж бүрэн зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс цалин хөлс нэмэгдэл урамшилд 21.7 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 2.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 4.5 сая төгрөг, нормативт зардалд 74.2 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 14.5 сая төгрөг, томилолт зочны зардалд 0.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 6.2 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 26.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 603.6 сая төгрөгийн 54 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 589.1 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжүүлж ажилласан байна. Өмнөх шийдвэрийн үлдэгдэлгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар, нягтлан бодох бүртгэлийн шууд бичилтээр хийсэн гүйлгээ, эм боох материалын нэр төрлийн зарцуулалт, жолоочийн тооцоо бодолт, илүү цагийн тооцоолол, байгууллагын удирдлага өөрт хамаарал бүхий байгууллагаас худалдан авалт хийж байгаа байдлыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 2.1 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй байсныг аудитын хугацаанд нөхөн шивүүлж анхан шатны баримтын шаардлагыг хангуулж, бараа материалын тайланд ангилал хооронд зөрүүлэн бүртгэсэн 5.9 сая төгрөг, тооцоо нийлсэн актаар баталгаажсан 1.4 сая төгрөгийн авлагыг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Эрүүл мэндийн салбарын ажиллагсдад олгосон тэтгэмжээс 0.4 сая төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Тайлант онд 2.4 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 3.2 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 589.1 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Чандмань сумын ЭМТ	7	15.5	3	9.5	1	0.4	2	5.6	1	